# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 45 (182)

**Монгол Улсын Хууль:**

- *Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай*
- *Онцгой албан татварын тэмдгийн тухай*

**Монгол Улсын Их Хурлын тогтоол:**

- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2001 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арванхоёрдугаар сарын 5 №45 (182)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

492. Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2000-11-16-ны хууль) 786

493. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай (2000-11-16-ны хууль) 786

494. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2000-11-17-ны хууль) 786

495. Гаалийн тарифын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2000-11-17-ны хууль) 787

496. Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2000-11-17-ны хууль) 787

497. Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай (2000-11-17-ны хууль) 787

498. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай (2000-11-17-ны хууль) 788

499. Онцгой албан татварын тэмдгийн тухай (2000-11-17-ны хууль) 789

500. Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2000-11-17-ны хууль) 790

501. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2000-11-17-ны хууль) 790

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

502. Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2001 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Дугаар 45 791

503. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 51 820

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6, 7 дахь заалт нэмсүгэй:

"6/аймгийн татварын албанд бүртгүүлж, тухайн аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн алтнаас бусад бараа, ажил үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар;

7/ашигт малтмалын хайгуул хийх болон ашиглалт явуулахад олгох тусгай зөвшөөрлийн төлбөр."

**2 дугаар зүйл.** Монгол Улсын төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

"1/тухайн төсвийн жилд улсын төвлөрсөн төсөвтэй харьцахаар тогтоосон болон нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын импортын барааны, мөн алтны борлуулалтанд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар";

2/ 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалт:

"1/аймаг, нийслэлийн Засаг даргаас сум, дүүргийн төсөвтэй харьцахаар тогтоосон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын болон онцгой албан татвар, аймгийн Засаг даргаас сумын төсөвтэй харьцахаар тогтоосон аж ахуйн нэгж, байгууллагын нэмэгдсэн өртгийн албан татвар".

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг "1.Иргэн нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг жилд нэг удаа автотехникийн улсын үзлэгт орохдоо төлнө. Хэрэв автотехникийн улсын үзлэгээс хойш автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийг импортоор оруулж ирсэн бол албан татварыг харьяалах татварын албанд тухайн жилдээ багтаан үлдсэн хугацаанд ногдох татварыг төлнө. Энэхүү албан татварын орлогоос тухайн орон нутгийн замын санд төвлөрүүлэх хувь хэмжээг Засгийн газар тогтооно." гэж өөрчлөн найруулсугай:

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9.2.10 дахь заалтыг "9.2.10.тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизм. Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг Засгийн газар батална."гэж өөрчлөн найруулсугай:

**2 дугаар зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6.2 дахь хэсгийн "13

хувиар" гэснийг "15 хувиар" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр**

**Улаанбаатар хот**

### ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг "1/тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөренгө оруулж байгаа гадаадын хөренгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизм. Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг Засгийн газар батална " гэж өөрчлөн найруулсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр**

**Улаанбаатар хот**

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт.

| | | | |
|---|---|---|---|
| 6.Пиво | - | литр тутмаас 0.20 | литр тутмаас 0.20 |

**2 дугаар зүйл.** Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "0.50" гэснийг "0.75", 4 дэх заалтын "0.20" гэснийг "0.30", 5 дахь заалтын "0.10" гэснийг "0.15" гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Онцгой албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалтаас "болон импортын" гэснийг хассугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр**

**Улаанбаатар хот**

### ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүн амын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 5 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйл:

"6 дугаар зүйл.Хувийн мал бүхий иргэний албан татвар ногдуулах малын тоог тодорхойлох

Хувийн мал бүхий иргэний албан татвар ногдуулах малын толгойн тоог хонин толгойд шилжүүлэн тодорхойлно. Татварын тооцоонд үхэр, адуу, тэмээ тус бүрийг 5 хонь, 1 ямааг 1.5 хонь гэж тооцно. Төсвийн жилд орлогын албан татвар ногдуулах малын тоог тодорхойлохдоо өмнөх жилийн эцэст тоологдсон малын тоог үндэс болгоно."

2/ 8 дугаар зүйлийн 5 дахь заалт:

"5/энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон хонин толгой тутамд дор дурдсан хэмжээгээр татвар ногдуулна:

| Аймаг, нийслэл | Татварын хэмжээ /төгрөг/ |
|---|---|
| Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Улаанбаатар, Орхон, | 100 |
| Архангай, Баянхонгор, Булган, Говь-сүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий, | 75 |
| Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан | 50 |

3/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7/мал бүхий өрхийн гишүүн бүрт хонин толгойд шилжүүлснээр 20 бог. Тухайн жилд албан татвар ногдуулах мал нь байгалийн гамшиг, гэнэтийн аюул, гоц халдварт өвчний улмаас хорогдсон бол зохих баримтыг үндэслэн татвар ногдуулах нийт малын тооноос хасч тооцно."

**2 дугаар зүйл.**Хүн амын орлогын албан татварын хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс" гэснийг "2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр** **Улаанбаатар хот**

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх эд хөрөнгөд /цаашид "үл хөдлөх эд хөрөнгө" гэх/ албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль тогтоомж**

2.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хууль тогтоомж нь Иргэний хууль[1], Татварын ерөнхий хууль[2], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл.Татвар ногдуулах үл хөдлөх эд хөрөнгө**

3.1.Монгол Улсын Иргэний хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлогдсон бүх төрлийн үл хөдлөх эд хөрөнгөд албан татвар ногдуулна.

**4 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч**

4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараах этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна:

4.1.1.өмчийн бүх төрөлд хамааргдах компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төлөөлөгчийн газар;

4.1.2.төрийн бус байгууллага, сан, шашны байгууллага;

4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

4.1.4.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

4.1.5.Монгол Улсад оршин суугч бус этгээд.

**5 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээ**

5.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно.

**6 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь, хэмжээ**

6.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс 0.6 хувиар тооцож ногдуулна.

**7 дугаар зүйл.Албан татвараас чөлөөлөх**

7.1.Дараахь үл хөдлөх эд хөрөнгийг

[1] *Иргэний хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дугаарт нийтлэгдсэн*

[2] *Татварын ерөнхий хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 1 дугаарт нийтлэгдсэн*

албан татвараас чөлөөлнө:

7.1.1.төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө;

7.1.2.орон сууц;

7.1.3.нийтийн эзэмшлийн барилга байгууламж.

**8 дугаар зүйл.Албан татвар ногдуулах, төсөвт төлөх**

8.1.Татвар төлөгч нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээгээр тооцно.

8.2.Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгийн жилийн албан татварыг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр тооцож төлнө.

8.3.Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор нэг удаа төлнө.

**9 дүгээр зүйл.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайланг тушаах хугацаа**

9.1.Албан татвар төлөгч нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалагдах татварын албанд тушаана.

9.2.Албан татварын тайланг татварын албад нэгтгэн гаргаж, 2 дугаар сарын 20-ны дотор Үндэсний татварын ерөнхий газарт ирүүлнэ.

9.3.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайлангийн маягтыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.

**10 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

10.1.Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр**

**Улаанбаатар хот**

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТЭМДГИЙН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад үйлдвэрлэсэн архи, тамхинд онцгой албан татварын тусгай тэмдэг /цаашид "тэмдэг" гэх/ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Онцгой албан татварын тэмдгийн тухай хууль тогтоомж**

2.1.Онцгой албан татварын тэмдгийн тухай хууль тогтоомж нь Онцгой албан татварын хууль[1], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл.Онцгой албан татварын тэмдгийг үйлдвэрлэх**

3.1.Тэмдгийг үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Монгол Улсын хуулийн этгээд үйлдвэрлэнэ.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан хуулийн этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай[2] хуулийн дагуу сонгон шалгаруулна.

3.3.Тэмдэг нь нууцлалын шаардлага хангасан сери, дугаартай байна.

**4 дүгээр зүйл.Онцгой албан татварын тэмдгийг олгох, хэрэглэх**

4.1.Тэмдгийг үндэсний татварын алба аж ахуйн нэгж, байгууллагын архи, тамхи үйлдвэрлэх зөвшөөрөл, тэдгээрийг худалдах, худалдан авах гэрээг үндэслэн олгоно.

4.2.Тэмдэггүй архи, тамхийг бэлтгэн нийлүүлэх, худалдах, тэмдгийг хуурамчаар үйлдэх, борлуулах, хэрэглэхийг хориглоно.

4.3.Тэмдгийн загвар, үнэ, тэмдэг олгох

*[1] Онцгой албан татварын хууль –"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 2 дугаарт нийтлэгдсэн*

*[2] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай -"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2000 оны 17 дугаарт нийтлэгдсэн.*

журмыг Засгийн газар тогтооно.

**5 дугаар зүйл.Архи, тамхины үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг**

5.1.Архи, тамхины үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэгтэй:

5.1.1.өөрийн үйлдвэрлэсэн бараанд тэмдэг нааж борлуулах;

5.1.2.үйлдвэрлэлд хэрэглэж байгаа спиртийн хэмжээ, үйлдвэрлэсэн архины тоо хэмжээг үнэн зөвөөр тодорхойлж, холбогдох татварын болон мэргэжлийн хяналтын байгууллагад өгч байх.

5.2.Архи, тамхины үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага үндэсний татварын албанаас авсан тэмдгийг бусдад шилжүүлэх, худалдахыг хориглоно.

**6 дугаар зүйл.Онцгой албан татварын тэмдгийн тухай хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

6.1.Онцгой албан татварын тэмдгийн тухай хууль зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын улсын байцаагч дараахь шийтгэл ногдуулна:

Энэ хуулийн 4.2; 5.1.1; 5.2-т заасныг зөрчсөн иргэнд 30000-50000, албан тушаалтанд 40000-60000, аж ахуйн нэгжид 150000-250000 төгрөгийн торгууль ногдуулж, тэмдэггүй болон хуурамч тэмдэг бүхий архи, тамхийг хураан авч, улсын орлого болгоно.

**7 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

7.1.Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр** **Улаанбаатар хот**

### АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**.Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "60 хоногийн" гэснийг "30 хоногийн" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл**.Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 7, 8 дугаар зүйлд "Монгол Улсын хилээр" гэснийг "Монгол Улсын нутаг дэвсгэрт" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл**.Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр** **Улаанбаатар хот**

### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 13, 14, 15, 16, 17 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

"13.Үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих нөхцөл бүрдэж байгаа бүс нутгийн аймгийн татварын албанд бүртгүүлэн, тухайн аймгийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг эхний жилд бүрэн чөлөөлж, дараагийн хоёр жилд 50

хувиар хөнгөлнө.

14.Үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих нөхцөл сул бүрдсэн бүс нутгийн аймгийн татварын албанд бүртгүүлэн, тухайн аймгийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг эхний жилд бүрэн чөлөөлж, дараагийн хоёр жилд 75 хувиар хөнгөлнө.

15.Энэ зүйлийн 14 дэх хэсэгт заасан үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих нөхцөл сул бүрдсэн аймгуудын төвөөс 100-гаас дээш километр алслагдсан сумдын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг эхний хоёр жилд бүрэн чөлөөлж, дараагийн жилд 50 хувиар хөнгөлнө.

16.Энэ зүйлийн 13, 14, 15 дахь хэсэгт заасан хөнгөлөлтөд хамаарах аймаг, сумдын жагсаалтыг Засгийн газар батална.

17.Энэ зүйлийн 13, 14, 15 дахь хэсгийн заалт тухайн аймгийн нутаг дэвсгэрт олборлох салбарын болон соггууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлж байгаа, мөн санхүүгийн болон татварын тайлангаа нэгтгэн, төвлөрсөн журмаар төсөвтэй тооцоо хийдэг аж ахуйн нэгж, байгууллагад хамаарахгүй."

**2 дугаар зүйл**. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтаас "Банкны зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгийг татвар ногдох орлогоос хасч тооцно." гэсэн 2 дахь догол мөр, мөн заалтын 6 дахь догол мөрөөс "болон сайн дурын", мөн хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалтаас "үнэт металлаас бусад эрдсийн түүхий эд" гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл**. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг "7.нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын орлого;" гэж өөрчлөн найруулсугай.

**4 дүгээр зүйл**. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 8, 9 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл**. Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр** **Дугаар 45** **Улаанбаатар хот**

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2001 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2001 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралт ёсоор батлсугай.

2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2001 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулж байхыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

*Монгол Улсын Их Хурлын 2000 оны 45 дугаар тогтоолын хавсралт*

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2001 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Бодлогын зорилт | Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх эзэн |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| | ***А. Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах хүрээнд:*** | | |
| **1.Эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийн хурдцыг нэмэгдүүлэх, татвар, мөнгөний оновчтой бодлого явуулах замаар дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 2001 онд 4.0 хувьд хүргэнэ.** | -Макро эдийн засгийн үндсэн тэнцвэрийг хангаж, тогтворжилтыг бататгахын зэрэгцээ дотоодын үйлдвэрлэлийг сэргээх, дэмжих, татвар, мөнгөний оновчтой бодлогыг хэрэгжүүлэх | жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| | -Үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх бизнесийн таатай орчин бүрдүүлж, түүнийг банк, санхүүгийн салбар дахь бүтцийн өөрчлөлтийн бодлогоор дэмжиж, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг уул уурхай болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, хүнс, газар тариалан, экспортын чиглэлийн үйлдвэрийг дэмжихэд түлхүү ашиглах | жилдээ | Ч.Ганзориг .<br>О.Чулуунбат |
| | -Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг 30.0 хувиас хэтрүүлэхгүй байх | жилдээ | О.Чулуунбат<br>Ч.Улаан |
| | -Банкны бүтцийн өөрчлөлттэй холбогдож зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийн хамт банкны байгууллагаас Засгийн газрын авсан цэвэр зээлийн хэмжээг бууруулах | жилдээ | Ч.Улаан |
| | -Засгийн газар, Монголбанкны хоорондох мэдээллийн солилцоо, төсөв, мөнгөний бодлогын уялдааг сайжруулах журам боловсруулж мөрдөх | I улирал | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| **2.Төгрөгийн бодит ханшийг тогтвортой байлгах бодлого явуулна.** | -Монгол Улсын гадаад өрсөлдөх чадвар, төлбөрийн тэнцлийн байдалд тогтмол дүн шинжилгээ хийж, ханшны оновчтой хэлбэлзлийг тогтворжуулах арга хэмжээг тухай бүр авах | жилдээ | О.Чулуунбат |
| | -Гадаад валютын цэвэр нөөцийг импортын барааны 12-оос доошгүй долоо хоногийн хэрэгцээг хангах хэмжээнд байлгах | жилдээ | О.Чулуунбат<br>Ч.Улаан |
| | -Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр төлбөр тооцоо хийх тухай журмын заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | жилдээ | О.Чулуунбат<br>Ч.Улаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Зарим бараа, бүтээгдэхүүний улирлын эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах үндсэн дээр үнийн хэлбэлзлийг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| **3.Инфляцийн түвшинтэй уялдуулан банкны зээл, хүүгийн уян хатан бодлого явуулна.** | -Инфляцийн түвшингийн бууралттай уялдуулан Монголбанкны үнэт цаасны хүүг бууруулах, улмаар арилжааны банкны зээлийн хүүг бууруулах | жилдээ | О.Чулуунбат<br>Ч.Улаан |
| | -Иргэн, аж ахуйн нэгж банкнаас зээл авах боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зээлдэгчийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр банкны тухай болон банкны үйл ажиллагаатай холбоотой бусад хуулиудад өөрчлөлт оруулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох | жилдээ | О.Чулуунбат<br>Ч.Улаан |
| **4.Төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 6.8 хувьтай тэнцэх хэмжээнд хүртэл бууруулна.** | -Төсвийн зарлага, санхүүжилтийн норм, нормативын үндэслэлийг салбар тус бүрээр хянан үзэж, сайжруулах | жилдээ | Ч.Улаан |
| | -Орон нутаг төсвөө бие даан бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрхийг өргөтгөж, үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх | III улирал | Ч.Улаан |
| **5.Татварын баазыг өргөтгөх, татвар цуглуулах үйл ажиллагаар сайжруулах арга хэмжээ авна.** | -Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль батлуулж, мөрдөх | I-II улирал | Ч.Улаан |
| | -Импортын бүх төрлийн тамхи, пиво, дарсанд ногдуулах онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх, архи, тамхинд тусгай тэмдэг /акцизын марк/ олгодог болох | жилдээ | Ч.Улаан |
| | -Гаалийн татвар ногдуулалт, бүртгэл, татвар төлөлтийн мэдээллийг нийтэд ил тод болгох, тогтмол мэдээлж байх | жилдээ | Ч.Улаан |
| | -Гадаадын хөрөнгө оруулалттай ноос, ноолуурын анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварт хамруулах | III улирал | Ч.Ганзориг |
| | -Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах | I улирал | Ч.Улаан |
| | -Орлогоо нуух, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох | жилдээ | Ч.Улаан |
| | -Мал бүхий иргэний малаас олох орлогын албан татварыг өөрчилж, хонин толгойд шилжүүлэн ногдуулж, бусийн ялгаатай тогтоон мөрдүүлэх | I улирал | Ч.Улаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Албан бус салбар, далд эдийн засгийн талаар судалгаа явуулж, түүнийг арилгах эрх зүй, эдийн засгийн цогц арга хэмжээ авах | жилдээ | Ч.Улаан |
| | -Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, бүрэн нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх | жилдээ | Ч.Улаан |
| | -Алт, зэс, ноолуур зэрэг стратегийн гол бүтээгдэхүүний борлуулалтын орлогын үнийн хэлбэлзлээс хамаарах нөлөөллийг багасгах | II улирал | Ч.Улаан |
| 6.Экспортыг дэмжих хүрээнд гадаад худалдааг өргөжүүлэх бодлого явуулна. | -Экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, мах, ноолуур зэрэг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Гадаад өрийг бууруулах чиглэлээр иж бүрэн судалгаа хийж, гадаадын зээл, тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | I-II улирал | Ч.Улаан<br>Л.Эрдэнэчулуун<br>Ч.Ганзориг |
| | -Гадаадын хөрөнгө оруулалтын тухай шинэчилсэн хуулийг батлуулж, мөрдөх | I-II Улирал | Ч.Улаан<br>Ч.Ганзориг<br>Л.Эрдэнэчулуун |
| | -Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, буцалтгүй тусламж, гадаадын иргэдийн хандиваар хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнг сайжруулах | жилдээ | Ч.Улаан холбогдох бусад сайд |
| 7.Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, арилжааны банкуудыг хувьчлах, удирдлагыг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар банкны эрүүл тогтолцоог бүрдүүлнэ. | -Банкны салбарт гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бий болгох | жилдээ | О.Чулуунбат |
| | -Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчлах бэлтгэлийг хангах, Худалдаа хөгжлийн банкийг хувьчлах | жилдээ | Ч.Улаан |
| | -Худалдаа хөгжлийн банкны хувьчлалд олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий стратегийн хөрөнгө оруулагчид болон олон улсын санхүүгийн байгууллагуудыг татан оролцуулж, банкны практикт шинэ техник, технологийг нэвтрүүлж, өрсөлдөөнийг дэмжих | III улирал | Ч.Улаан<br>О.Чулуунбат |
| | -Хөгжлийн томоохон төслүүдийг урт хугацаанд санхүүжүүлэх чиглэлээр Хөдөө аж ахуйн банкны үйл ажиллагааг өргөтгөн | II улирал | Ч.Улаан<br>О.Чулуунбат |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | зохион байгуулах | | |
| | -Хөдөөгийн иргэдэд мөнгө, зээл, төлбөрийн үйлчилгээг ойртуулах зорилгоор орон нутгийн төвүүд, сумдын холбооны салбарыг ашиглан банкны үйлчилгээг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах | I-II Улирал | О.Чулуунбат Б.Жигжид |
| | -Банкны хамтын удирдлагын зарчмыг нэвтрүүлж, удирдлага, боловсон хүчний ур чадварыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх | жилдээ | О.Чулуунбат |
| | -Өр барагдуулах тухай хууль батлуулан мөрдөж, банкны байгууллагын чанаргүй зээлийг төлүүлэх ажлыг эрчимжүүлэх | жилдээ | Ч.Улаан О.Чулуунбат |
| | -Санхүү, төлбөрийн сахилга батыг чангатгаж, санхүүгийн гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ тууштай биелүүлдэг соёлыг хэвшүүлэхэд төр, засаг, банк, санхүү, хууль, хяналтын байгууллагуудын оролцоо, хариуцлагыг өндөржүүлэх | жилдээ | Ч.Улаан О.Чулуунбат |
| | -Хадгаламжийн банкийг арилжааны хэлбэрт шилжүүлж эхлэх | I улирал | Ч.Улаан О.Чулуунбат |
| | -Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Засгийн газрын гаргасан өрийн бичгийн арилжаалагдах боломжийг бүрдүүлэх | II улирал | Ч.Улаан |
| | -Банкны болон Засгийн газрын өрийг барагдуулах, зохицуулах | жилдээ | Ч.Улаан О.Чулуунбат |
| **8. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа дэмжих, даатгалын компаниудын хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг хөрөнгө оруулалтад ашиглах хөшүүргийг бий болгохтой холбогдсон эрх зүйн орчныг бүрдүүлнэ.** | -Хадгаламж, хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангах чадвар бүхий банк бус санхүүгийн байгууллагууд хөгжих эрх зүйн болон хяналтын тогтолцоог бүрдүүлэх | жилдээ | Ч.Улаан О.Чулуунбат |
| | -Даатгалын болон бусад сангуудын үлдэгдэл хөрөнгийг хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зориулалтаар ашиглах эрх зүйн орчныг бий болгох | IV улирал | Ч.Улаан |
| **9. Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх орчныг бүрдүүлж, хүрээг нь нэмэгдүүлэн мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.** | -Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, Үнэт цаасны тухай хуулийг шинэчлэн батлуулахын хамт холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах | жилдээ | С.Гүндэнбал Ц.Нямдорж |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийг боловсруулах | IV улирал | С.Гүндэнбал<br>Ц.Нямдорж |
| | -Санхүүгийн зах зээлийг бүрдүүлэх, хөгжүүлэх, шинэ төрлийн үнэт цаас гаргаж зах зээлийн арилжааны чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах | Жилдээ | Ч.Улаан<br>О.Чулуунбат<br>С.Гүндэнбал |
| | -Санхүүгийн түрээс болон үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх, үнэт цаасны тухай мэдээллийг олон нийтэд хүргэх асуудлыг шинэ шатанд гаргах | жилдээ | С.Гүндэнбал |
| | -Хувьцаат компаниудын үнэт цаасны бүртгэлийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэн, үнэт цаасны арилжааны хяналтын тогтолцоог сайжруулж, зэрэглэл тогтоох | жилдээ | С.Гүндэнбал |
| **10.Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, нэр төрлийг олшруулж хариуцлагыг дээшлүүлнэ** | -Газар тариалан болон хариуцлагын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Даатгалын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох | III-IV улирал | Ч.Улаан |
| | -Мал сүргийг байгалийн гамшгаас хамгаалах тогтолцоог бий болгох, Малын даатгалын тухай хууль батлуулан мөрдөх | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Хувийн хадгаламжийг эрсдэлээс хамгаалах зорилгоор иргэдийн хадгаламжийн даатгалын тогтолцооны үндсийг тавих | III улирал | Ч.Улаан |
| | -Даатгалын компаниудын нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг олон улсын даатгалын бүртгэлийн жишигт нийцүүлэн боловсронгуй болгох | жилдээ | Ч.Улаан |
| **11.Хувьчлалын гажуудлыг арилгаж, хуулийг чанд сахин хэрэгжүүлэх хариуцлагыг өндөржүүлж, өмч хувьчлалыг эрчимжүүлнэ.** | -Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хувьчлалын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох | I улирал | Ч.Улаан<br>Ц.Нямдорж |
| | -Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, хувьчлалын хөтөлбөрийг батлуулж, үнэ цэнэтэй томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалыг эхлүүлэх | I улирал | Ч.Улаан |
| | Монросцветмет нэгдэл, Хар төмөрлөгийн үйлдвэр, Монголболгаргео үйлдвэр, Монголамикал компани зэрэг томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын үзэл баримтлалыг гаргаж, хуульд заасан аргуудаас оновчтойг нь сонгон хэрэглэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг хувьчлалд түлхүү оролцуулах | жилдээ | Ч.Улаан<br>Ч.Ганзориг |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар нийгмийн салбарын хувьчлалыг эхлүүлэх | I улирал | Ч.Улаан<br>Ш.Батбаяр |
| | -Төрийн өмчийн түрээсийн бодлогыг тодорхойлж, төрийн өмчтэй холбоотой эрх зүйн актуудыг шинэчлэн боловсруулах | I улирал | Ч.Улаан |
| | ***Б. Үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогын хүрээнд:*** | | |
| **1.Татварын механизмыг оновчтой ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, дотоодын үйлдвэрлэл хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого явуулна.** | -Эдийн засгийн шинэттэлийг эрчимжүүлэн, бүтцийн өөрчлөлтийг хурдасган, бизнесийг хөгжүүлэх аятай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн бодлого явуулах | жилдээ | Ч.Улаан<br>Ч.Ганзориг |
| | -Япон Улсын Засгийн газраас олгох хоёр үе шаттай зээлийг экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд ашиглах | жилдээ | Ч.Улаан<br>Ч.Ганзориг<br>Л.Эрдэнэчулуун |
| | -"Ноос", "Арьс шир" хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлж, эдгээр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөр, адууны дэл, сүүл, арьс, ширний бэлтгэлийн стандартыг шинэчилж, түүхий эдийн чанарыг сайжруулах замаар экспортыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | жилдээ | Ч.Ганзориг |
| **2.Түлш, эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийж, хангамжийг сайжруулна.** | -Чойбалсангийн ДЦС-ын өргөтгөл, шинэчлэлтийг дуусган бүсийн хэрэглэгчдийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж, хамрах хүрээг өргөтгөх | жилдээ | Б.Жигжид |
| | -Баянтээгийн дулааны цахилгаан станц, Үенч, Дөргөн, Чаргайт, Эгийн гол,Улаанбоомын усан цахилгаан станцыг барих судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийг хийх, санхүүгийн эх үүсвэрийг олох | жилдээ | Б.Жигжид |
| | -Эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийх | жилдээ | Б.Жигжид |
| | -Хөдөөгийн малчин өрхийн эрчим хүчний хэрэглээг нар, салхины эрчим хүчний эх үүсвэрээр хангах "100000 нарны гэр" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Б.Жигжид |
| | -Нүүрсний уурхайнуудын техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөдөө орон нутгийн нүүрсний хангамжийг сайжруулах | жилдээ | Б.Жигжид |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Сайн чанарын нүүрсний орд /Улаан-Овоо, Алагтогоо/-ыг шинээр эзэмших, Шарын голын уурхайн орчимд хайгуул хийж нөөцийг өсгөх замаар Дархан, Эрдэнэтийн бүс нутгийн нүүрсний хангамжийг сайжруулах | жилдээ | Б.Жигжид |
| **3.Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлж, геологи хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлнэ.** | -Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай, Газрын тухай болон бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах<br>-Үйлдвэрлэл, хайгуул явуулахгүй байгаа орд газрын ашиглалтын лицензийн төлбөрийг уян хатан тогтолцоонд шилжүүлэх | II улирал | Ч.Ганзориг |
| | - Геологи хайгуулын ажилд их хэмжээний хөрөнгө гаргадаг хөрөнгө оруулагчдыг Тогтвортой байдлын гэрээнд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | III улирал | Ч.Ганзориг<br>Ч.Улаан |
| | -Ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг хувийн хөрөнгө оруулалтаар явуулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх | IV улирал | Ч.Ганзориг |
| | -Нийт 28.9 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд 1:200000-ын геологи, ашигт малтмалын зургийг зохиож, хэтийн төлөв бүхий талбайнуудыг ялган үнэлгээ өгөх, үүнээс шинээр 10 мянган хавтгай дөрвөлжин километр талбайд геологийн зураглал, эрлийн ажлыг эхлүүлэх | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Ашигт малтмалын орд илрүүлэх хэтийн төлөв бүхий талбай болон хил орчмын нутаг дэвсгэрийн 6200 хавтгай дөрвөлжин километр талбайд геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн явуулж, 17.6 мянган хавтгай дөрвөлжин километр талбайн геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг шинээр эхлэн 1:50000-ын масштабтай зураг зохион, хэтийн төлөв бүхий хэсгүүдэд үнэлгээ өгөх | жилдээ | Ч.Ганзориг |
| | -Газар зүйн мэдээллийн сүлжээг түшиглэн олон улсын мэдээллийн технологид нийцсэн геологийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлж, чулуун сан, гидрогеологийн сан, стратографын санг бүрдүүлэх | жилдээ | Ч.Ганзориг |
| | -1:200000-ын масштабын зураглалын ажлын стандарт /шалгуур болзол/ зохиож, өмнө хийгдсэн зураглалын ажлыг шүүж, өнөөгийн шалгуур болзлын шаардлага хангасан эсэхийг үнэлэх | жилдээ | Ч.Ганзориг |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| **4.Малчин өрх болон фермерийн аж ахуйн эрх зүй, эдийн засгийн харилцааг хуульчилж, малчид хоршоо, фермерийн аж ахуй байгуулах үүсгэл санаачлагыг дэмжинэ.** | -Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бэлчээр ашиглалтын төлбөрийг шинэчлэн тогтоож, алслагдсан болон говийн бүс, хязгаар нутагт бэлчээрийн төлбөрийг хөнгөлөх механизмыг бүрдүүлж, даац ашиглалтыг эдийн засгийн аргаар зохицуулах | жилдээ | Д.Насанжаргал<br>У.Барсболд |
| | -Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний төлбөрийг тодотгон шинэчилж хэрэгжүүлэх | Ш улирал | Д.Насанжаргал<br>Ч.Ганзориг |
| | -Малчин өрх, фермерийн аж ахуйн эдийн засгийн харилцааг зохицуулсан эрх зүйн үндсийг бий болгох | жилдээ | Д.Насанжаргал |
| **5.Мал сүрэг төрийн хамгаалалтад байх тогтолцоог зах зээлийн нөхцөлд нийцүүлэн төгөлдөржүүлэх, бэлчээр усжуулалт, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.** | -Хадлан бэлтгэх, малын тэжээлийн үйлдвэрлэл, борлуулалт эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын дунд сонгон шалгаруулах уралдаан зарлан улс, аймгийн тэжээлийн нөөцийг бүрдүүлэх журмыг бий болгож, хэрэгжүүлэх | III улирал | Д. Насанжаргал |
| | -Улсын аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн цэгүүдийн агуулах, хашаа саравчийг шинэчлэн засварлаж өвс, тэжээл хадгалах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах | III улирал | Д. Насанжаргал |
| | -Бэлчээрийн төлбөрийн хуримтлалын тодорхой хэсгийг бэлчээр усжуулах, ургамлын сан хөмрөгийг нөхөн сайжруулахад ашиглах | жилдээ | Д. Насанжаргал<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Бэлчээрийн даацыг шинэчлэн тогтоох, төлөв байдлыг үнэлэх үндсэн дээр бэлчээр сэлгэх, өнжөөх, бордох, хаших, эзэмших, ашиглалтыг сайжруулах зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх | жилдээ | Д. Насанжаргал<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Инженерийн хийцтэй худаг, уст цэгт засвар, шинэчлэлтийн ажил хийх | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Малчид болон мал аж ахуйн чиглэлийн аж ахуйн нэгжийн удирдлагад зориулж Даатгалын тухай хуулийг сурталчилах, сургалт явуулах, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах | жилдээ | Д.Насанжаргал |
| **6.Мал сүргийг байгалийн гамшгаас хамгаалах тогтолцоо, гамшгийн тусламжийн сүлжээг бүрдүүлнэ.** | -Мал аж ахуйг ган, зуд зэрэг байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоо, холбогдох эрх зүйн орчныг бий болгох | II улирал | Д.Насанжаргал |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Бүс нутгуудад аймаг дундын отрын нөөц нутгийг бий болгох, цаг агаарын тааламжгүй үед мал сүргийг өвөлжүүлэх, хаваржуулах нөхцөл бүрдүүлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Дэлхийн банкны зээл, бусад эх үүсвэрийн хүрээнд 1999-2000 оны зуднаар малгүй болсон болон цөөн малтай айл өрхийг малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэх | жилдээ | Д.Насанжаргал Ч.Улаан |
| **7. Малын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог боловс- ронгуй болгож, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаа- лах, эрх зүйн зохицуулалтыг зах зээлийн нөхцөлд тохируулан шинэчилнэ.** | -Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, хорио цээрийн арга хэмжээний эрх зүйн орчныг зах зээлийн зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулах | II-III улирал | Д.Насанжаргал |
| | -Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, малын бруцеллёзтой тэмцэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэн, ям, сурьеэ, лейкоз, адууны халдварт цус багадах өвчнийг оношлох ажлын хүрээг өргөтгөх | жилдээ | Д. Насанжаргал |
| | -Ноолуурыг чанаржуулах зорилгоор ямааны үүлдэр угсааг сайжруулах хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| **8. Газар тариалангийн үйлд- вэрлэлийн уналтыг зогсоож, түүний тогтвортой хөгжих нөхцөлийг хангахад чиглэсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлнэ.** | -Газар тариалан эрхлэх, тариалангийн хөрсний үржил шимийг сайжруулах, удаан хугацаанд тогтвортой хүртэх, хамгаалах, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэгдсэн эрх зүй, эдийн засгийн орчныг бий болгох | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Улсын аюулаас хамгаалах үрийн нөөцөд үр бэлтгэх үйл ажиллагааг зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Тариалангийн үндсэн бүсүүдэд элит сортын үр үйлдвэрлэх өрхийн аж ахуй, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагуудыг дэмжих замаар буудайн чанар сайтай үр бэлтгэх | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Тариалангийн эдэлбэр газрын эзэмшил, ашиглалтыг сайжруулах зорилгоор ашиглаагүй тариалангийн талбайн төлбөрийг нэмэгдүүлж, уриншилсан болон эзэмшсэн газраа үр ашигтай ашиглаж тогтвортой ургац авч байгаа аж ахуйн нэгж, иргэн, байгууллагыг газар ашиглалтын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх | I улирал | Д.Насанжаргал |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | чиглэлээр Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | | |
| | -Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн тогтворжуулах зорилгоор 2001 онд чанар сайтай уринш бэлтгүүлэх ажлыг зохион байгуулахад хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | II-III улирал | Д.Насанжаргал |
| | -Тариалангийн үндсэн бүсүүдэд техник, технологийн шинэчлэлийг гадаадын зээл, тусламж, лизингийн үйлчилгээ зэргийг ашиглан хөнгөлөлттэй нөхцөлөөр хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Газар тариалан эрхлэх, хадлан, тэжээл бэлтгэхэд техникийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж бий болгон хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төвлөрүүлэн дэмжлэг үзүүлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| **9.Газрын аж ахуйг эргэлтэд оруулах сонирхлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна** | -Иргэдийн газар эзэмших, ашиглах эрхийг өргөтгөж, газар тариалан эрхлэгч иргэн, хоршоо, бусад аж ахуйн нэгж, байгууллага газрыг удаан хугацаагаар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Газрын ашиглалтыг сайжруулан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр эрчимтэй ажиллах | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Газар тариалан, мал аж ахуйн салбарт оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, түүний тогтвортой ажиллах нөхцөлийг хангах зорилгоор тэдгээрт эзэмшил газрыг урт хугацаагаар түрээслүүлэх хөшүүрэг, эрх зүйн орчныг бий болгох | жилдээ | Д.Насанжаргал |
| **10.Хүнсний үйлдвэрлэлийн стандарт, чанарын хяналтын тогтолцоог төгөлдөржүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ** | -Хүнсний үйлдвэрлэлийн стандарт, чанарын тогтолцоог төгөлдөржүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шинэ нөхцөлд нийцүүлэн зохион байгуулах | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Хүнсний мэргэжлийн хяналтын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | П-Ш улирал | Д.Насанжаргал |
| | -Хүнсний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах, өөрийн лабориторитой үйлдвэр бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Хилийн боомт, гүний гаалийн байгууллагуудын мэдээллийг | жилдээ | Д.Насанжаргал |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | хүнсний хяналт, сорилт, шинжилгээ, стандартын байгууллага, албад шуурхай авч байх мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох | | |
| | -Ангийн мах, загас, самар, жимс, мөөг, тослог ба үнэрт ургамал зэрэг байгалийн баялгийг уламжлалт арга, дэвшилтэт технологиор боловсруулж, гадаадын жуулчид, экспортын хэрэгцээнд ашиглах | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Монгол малын махыг экспортлох шинэ зах зээл олох, мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүдийн техник технологийн ариун цэврийн нөхцөлийг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэх замаар махны экспортыг нэмэгдүүлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| | -Мах, гурилын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | жилдээ | Д.Насанжаргал |
| **11.Аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбар болгох, түүний удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах** | -Аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар дундын удирдлага, зохицуулалтыг бий болгох | жилдээ | Б.Жигжид |
| | -Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын төслүүдийг хэрэгжүүлэх | жилдээ | Б.Жигжид |
| | -Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх, соёлын нөөц газар нутгийг өргөтгөх боломжийг судлан шийдвэрлэх | жилдээ | Б.Жигжид<br>У.Барсболд |
| **12.Автотээврийн олон улсын харилцааг өргөтгөж техникийн хяналтын тогтолцоог сайжруулна** | -Улаанбаатарт автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын оношлогооны 5 суурин лаборатори, хөдөө орон нутагт 3 явуулын лаборатори байгуулах | жилдээ | Б.Жигжид |
| | -Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Бүгд Найрамдах Белорусь улс болон Европын зарим орнуудтай байгуулах | жилдээ | Б.Жигжид |
| **13. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлтийг дэд бүтцийн хөгжлөөр дэмжинэ** | -Авто замын сүлжээг өргөтгөх зорилгоор баруун, зүүн бүсүүдийг холбосон хөндлөн тэнхлэгийн зам буюу мянганы замыг барих ажлыг үргэлжлүүлж, уг ажилд хөрөнгө, хүн хүчний нөөцийг төвлөрүүлж, баруун бүсийн босоо тэнхлэгийн замын зураг төслийг | жилдээ | Б.Жигжид |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | хийж , барьж эхлэх | | |
| | -Замын сангийн хөрөнгөөс Улаанбаатар хотын замын засварт зарцуулагдах буюу ногдох хөрөнгийг тусгаарлан өгөх | жилдээ | Б.Жигжид |
| | -Иргэний нисэхийн салбарт холбоо, навигацын шинэ техник технологи нэвтрүүлж, найдвартай ажиллагааг дээшлүүлэх | жилдээ | Б.Жигжид |
| | -Аймаг, хотуудыг мэдээлэл холбооны олон улсын болон дотоодын сүлжээнд холбох, техникийг шинэчлэх арга хэмжээ авах | жилдээ | Б.Жигжид |
| | -Төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор төмөр замын тээврийн сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах | жилдээ | Б.Жигжид |
| **14.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, нийтийн аж ахуйг сэргээн хөгжүүлнэ.** | -Барилгын салбарын нэгдсэн бодлого, хөгжлийн чиг хандлага, ерөнхий төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх | III улирал | Б.Жигжид |
| | -Барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүх талаар бэхжүүлж, шинэ материал, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, ур чадварыг дээшлүүлэх замаар гадаадын ижил төстэй мэргэжлийн байгууллагуудтай өрсөлдөх боломжийг бүрдүүлэх | жилдээ | Б.Жигжид |
| | -Улаанбаатар, Ховд, Улаангом, Өлгий, Мөрөн, Улиастай хотуудын нийтийн аж ахуйг сэргээх ажлыг хэрэгжүүлж, төв болон зүүн аймгуудын төвийн нийтийн аж ахуйг шинэчлэх ажлыг эхлэх | IV улирал | Б.Жигжид |
| | -Зарим аймгийн төвийн нийтийн аж ахуй, усан хангамжийг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах цогцолбор арга хэмжээ авах | жилдээ | Б.Жигжид |
| | -Бүх аймгийн төв, сумдыг нийтийн халуун устай болгох ажлыг эхлэх | жилдээ | Б.Жигжид |
| | -Орон сууц барих санг бүрдүүлж иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, нийслэлд төрийн албан хаагчид, залуучуудад зориулсан 1000 айлын орон сууцны цогцолборыг барьж эхлэх | жилдээ | Б.Жигжид |
| | -Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийн мэдлийн орон сууцыг хувьчлах асуудлыг судалж шийдвэрлэх | жилдээ | Б.Жигжид |
| | -Дэлхийн мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан Кадастрын зураглалын шинэ технологийг эзэмших, үндэсний | жилдээ | Б.Жигжид |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | геодезийн сүлжээг шинэчлэн байгуулах, газрын бүртгэл, мэдээллийн сан бий болгох үндсийг бүрдүүлэн газар ашиглалт, газрын харилцааг хот байгуулалт, төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх | | |
| | -Нийслэл, аймгийн төв, томоохон хот, суурин газрууд болон одоо байгаа барилгууд, тэдгээрийн инженерийн шугам сүлжээ, байгууламжуудад газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлж, паспортжуулах | жилдээ | Б.Жигжид |
| | -Гэр хорооллыг нэгдсэн бодлогын дагуу хөгжүүлж, усан хангамж, холбоо, тээвэр, нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах, эдгээр салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих | жилдээ | Б.Жигжид |
| ***В. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээнд:*** | | | |
| **1.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтыг бий болгож, бүс нутгийн хүрээнд орон нутгийн хөгжлийг тэтгэхэд чиглэсэн үйл ажиллагаар бүх шатанд дэмжин зохион байгуулна.** | -Бүсчилсэн хөгжлийн үзэл баримталыг батлуулан хэрэгжүүлж эхлэх | I улирал | Ч.Улаан<br>Б.Жигжид |
| | -Бүсчилсэн хөгжлийг төрөөс зохицуулах удирдлага, зохион байгуулалтын бүтцийг бий болгох | II улирал | Ч.Улаан<br>Ц.Нямдорж |
| | -Эдийн засгийн бүс тус бүрийн хөгжлийн стратегийг тодорхойлох ажлыг эхлэх | жилдээ | Ч.Улаан |
| | -Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүдэд худалдаа-эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах | жилдээ | Ч.Улаан<br>Ч.Ганзориг |
| | -Бүс нутгийн хөгжлийг татвар, хөрөнгө оруулалт, зээлийн ялгавартай бодлогоор дэмжих, бөөний худалдааны сүлжээ байгуулах хөтөлбөр боловсруулах | III-IV улирал | Ч.Улаан<br>Ч.Ганзориг |
| | -Улс орны дотоод, гадаад зах зээлийн эрэлт, хэрэгцээ, бүсчилсэн хөгжлийн чиг хандлага, нөөц боломжийг бодолцон хүн амын нутагшилт, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн ерөнхий төсөл, төлөвлөгөөг шинэчлэн батлуулах | жилдээ | Б.Жигжид<br>Ч.Улаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| **2.Байгаль орчны бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаар чиглүүлж, экологийн тэнцлийг хангах, доройтсон орчныг нөхөн сэргээх арга хэмжээ авна.** | -Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах | жилдээ | У.Барсболд |
| | -Газрын шинэчлэл хийх ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжийн газар ашиглах, эзэмших эрхийг баталгаажуулах, газар тариалангийн бүс нутагт бэлчээр эзэмших, газар олголт, эзэмшилтийг журамлах, доройтсон орчныг нөхөн сэргээх чиглэлээр газрын тухай холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах | жилдээ | У.Барсболд<br>Ц.Нямдорж |
| | -Байгалийн нөөц баялаг ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр газар, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, шинээр ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх | жилдээ | У.Барсболд<br>Ч.Улаан<br>Ш.Батбаяр<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -10000 га талбайд ойг нөхөн сэргээх арга хэмжээ авч, Бугант, Хялганат, Тосонцэнгэл, Түнхэл, Дулаанхаан, Батширээт, Эрээн тосгонуудад мод үржүүлэх ажлыг эрчимжүүлэх, тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх, урамшуулах | жилдээ | У.Барсболд |
| | -Байгаль орчны салбарын төв, орон нутгийн байгууллагуудын оновчтой бүтцийг бүрдүүлж, байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх | жилдээ | У.Барсболд<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Говийн бүсийн аймаг, сумын түлшний хангамжийг шийдвэрлэх замаар загийн ой, бутлаг ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах | жилдээ | У.Барсболд |
| | -Бүх нийтэд экологийн боловсрол олгох, үндэсний зан уламжлалыг сэргээн хэвшүүлэхэд албан болон албан бус сургалт, сурталчилгаар ашиглах | жилдээ | У.Барсболд<br>А.Цанжид |
| | -Агаарын бохирдлыг бууруулах эдийн засаг, эрх зүйн үндсийг бүрдүүлэх | жилдээ | У.Барсболд |
| | -Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан гэр хорооллын 15 мянгаас доошгүй айл өрхийг бүрэн шаталттай болон сайжруулсан зуухаар хангах | жилдээ | У.Барсболд<br>Нийслэлийн Засаг дарга |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Монгол орны байгалийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий 900.0 мянган га газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглүүлэн байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх | жилдээ | У.Барсболд |
| | -Зарим нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, тэдгээрийн амьдрах, нөхөн үржих нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах | жилдээ | У.Барсболд |
| | -Улаанбаатар хотын хуурай хог хаягдлыг ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах | жилдээ | У.Барсболд<br>Нийслэлийн Засаг дарга |
| | -Монгол орны цөлжилтийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, түүнтэй тэмцэх, бэлчээрийн талхагдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | жилдээ | У.Барсболд<br>Д.Насанжаргал |
| | -Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газрыг тодорхой болзолтойгоор, удаан хугацаагаар түрээслүүлэх нөхцөл боломжийг судлан, эрх зүйн үндсийг бүрдүүлэх | жилдээ | У.Барсболд |
| | -Ус цаг уур, аэрологийн станцад технологийн шинэчлэлт хийж, орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөн, озон задалдаг бодисын тооллогыг зохион байгуулах | жилдээ | У.Барсболд |
| | -Эрдэнэт үйлдвэрийн хаягдлаас гарч байгаа цагаан тоосыг ашиглах, цэвэршүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх | жилдээ | У.Барсболд |
| | ***Г. Хүний хөгжил, нийгмийн бодлогын хүрээнд:*** | | |
| **1.Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.** | -Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг бүс нутаг, төв, орон нутгийн хөгжлийн хандлагатай уялдуулан зохицуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авах | жилдээ | Ш.Батбаяр<br>А.Цанжид<br>П.Нямдаваа |
| | -Хүн амын нийгмийн бүлгүүдийн төрөлжсөн хөтөлбөр, төслүүдийн үр дүнг дээшлүүлэх, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан<br>П.Нямдаваа |
| | -Хүн ам, орон сууцны тооллогын дүнг үндэслэн иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөр боловсруулж, залуу гэр бүлд орон сууцны зориулалтаар зээл олгох санг бүрдүүлэх | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах бодлого боловсруулах | жилдээ | Ө.Энхтүвшин<br>Ш.Батбаяр<br>Б.Жигжид |
| | -Хүүхэд, залуучуудын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Хүүхдийг хөгжүүлэх талаар 2010 он хүртэл баримтлах үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах. | жилдээ | Ш.Батбаяр<br>А:Цанжид<br>П.Нямдаваа<br>Ч.Улаан |
| | -Хүн амын шилжих хөдөлгөөнийг нийгэм, эдийн засаг, хүн ам зүй, экологийн хүчин зүйлээр судлах ажлыг НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлэх | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Хүн амын шилжилт хөдөлгөөн ихтэй бүс нутгуудад шилжилтийг хязгаарлах, сааруулах арга хэмжээг бүсийн болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан<br>П.Нямдаваа<br>А.Цанжид |
| **2.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад түлхүү анхаарна.** | -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаар хууль боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Ажилгүйдлийн даатгалын сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн дотоодын болон гадаадын байгууллагаас олгох зээл тусламж, хандив зэрэг хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний сан байгуулж ажиллуулах | III улирал | Ш.Батбаяр |
| | -Ажилгүйдлийг бууруулах, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, Хоршоо хөгжүүлэх, Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан<br>А.Цанжид<br>Ч.Ганзориг<br>Д.Насанжаргал |
| | -Ажлын байр бий болгоход зориулан төрийн бус байгууллага, банк бус санхүүгийн байгууллагын шугамаар жижиг зээл олгох ажиллагаар өргөжүүлэх | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |
| | -Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэхийг дэмжих зорилгоор зээлийн сан байгуулж ажиллуулах, өмнө байгуулагдсан сангийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх | жилдээ | Ч.Ганзориг<br>Д.Насанжаргал<br>Ш.Батбаяр |
| | -Гадаадад ажиллаж байгаа иргэдийн эрхийг хамгаалах, гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах эрх зүйн орчныг бүрдүүлэх | жилдээ | Ш.Батбаяр<br>Ц.Нямдорж<br>Л.Эрдэнэчулуун |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудыг шинэчлэх | жилдээ | Ш.Батбаяр |
| **3.Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, нийгмийн эмзэг хэсгийн аж байдлыг дээшлүүлнэ.** | -Тахир дутуу болон одой хүмүүсийг ажлын байраар хангах арга хэмжээг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх, түүнд үнэлгээ өгөх | III улирал | Ш.Батбаяр |
| | -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих идэвхтэй бодлого явуулах замаар хөдөлмөр эрхлээгүй хүний тоог бууруулж, ажилгүйдлийн түвшинг эдийн засгийн идэвхтэй хүн амын 5.0 хувиас хэтрүүлэхгүй байх | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Хөдөлмөрийн багтаамж ихтэй, нийтийг хамарсан ажилд, ялангуяа байгаль орчныг сэргээхэд ажилгүй хүмүүс, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулах замаар ажлын түр байраар хангах | жилдээ | Ш.Батбаяр<br>У.Барсболд |
| | -Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдуулан хянан үзэж гадаадын хандивлагчдын тусламжтайгаар хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх | II улирал | Ш.Батбаяр |
| | -Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэдийн тахир дутуугийн тэтгэвэр авч байх хугацааны тэтгэврийн даатгалыг шимтгэл болон тэднийг асрах, сувилах, эмчлэх зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлөх журмыг боловсруулж, мөрдөх | III улирал | Ш.Батбаяр |
| | -Хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг шийдвэрлэх, цаашид таслан зогсоох талаар цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |
| **4.Хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ** | -Төсвийн байгууллагын ажиллагчдын бүтээл, ажлын чанар, үр дүнг харгалзан цалин хөлс олгох шинэ журмыг туршиж нэвтрүүлэх | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Төрийн болон төсвийн байгууллагын ажилтны цалин хөлс, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг 2001 онд инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх | II улирал | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |
| | -Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн нөхөн олговрын доод хэмжээг нэмэгдүүлэх | II улирал | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |
| | -Ахмад дайчид, алдар цолтонд үзүүлэх тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх | II улирал | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |
| **5.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгож, чадавхийг дээшлүүлнэ.** | -Азийн хөгжлийн банктай хамтран Нийгмийн хамгааллын хөгжлийн хөтөлбөр төслийг хэрэгжүүлэх | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Хөдөлмөр зохицуулалтын албадын нэгдсэн тогтолцоог улсын хэмжээнд бүрдүүлэх, боловсон хүчин, санхүүгийн талаар бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Ш.Батбаяр |
| | -Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг сайжруулах, шимтгэлийн өр авлагыг барагдуулах арга хэмжээ авах | жилдээ | Ш.Батбаяр<br>Ч.Улаан |
| | -Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын заавал даатгуулах хэлбэрт хамруулах эрх зүйн орчныг бий болгох | I-II улирал | Ц.Нямдорж<br>Ш.Батбаяр |
| **6.Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний стандартыг тогтоож, санхүүжилтийг боловсронгуй болгоно.** | -Сумын болон өрхийн эмнэлгийн түвшинд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний багц, түүний стандартыг тогтоож, хүн амын тоотой нь уялдуулан санхүүжүүлэх аргад шилжүүлэх | жилдээ | П.Нямдаваа<br>Ч.Улаан |
| | -Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, өнөөгийн нөхцөлд зохицуулан нэгдсэн цогц бодлого явуулах замаар хөтөлбөр, төслийн үр дүнг дээшлүүлэх | жилдээ | П.Нямдаваа |
| | -Өрхийн болон сумын эмнэлгийг нэг хүнд ногдох зардлаар санхүүжүүлэх | жилдээ | П.Нямдаваа<br>Ч.Улаан |
| | -Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний багцыг шинэчлэн тогтоож мөрдөх | I-III улирал | П.Нямдаваа<br>Ш.Батбаяр |
| | -Эрүүл мэндийн салбарын санхүүгийн удирдлагыг боловсронгуй болгох олон улсын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | жилдээ | П.Нямдаваа |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Төрийн өмчийн эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, шинжилгээг үнэ төлбөргүй болгох бэлтгэл ажлыг хангах | жилдээ | П.Нямдаваа<br>Ч.Улаан |
| **7.Улаан бурхан өвчнийг эрс бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, дархлаажуулалтын сан байгуулна.** | -Улс, олон нийт, хувийн компаниуд болон олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Дархлаажуулалтын сан байгуулж, санг бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулж, батлуулах, үр ашигтай ашиглах хөшүүрэг бий болгож, мөрдүүлэх | жилдээ | П.Нямдаваа<br>Ч.Улаан |
| | -Халдварт саа өвчний устгалыг баталгаажуулах, улаан бурхан өвчний эсрэг вакцинаар 0-7 насны хүүхдийг вакцинжуулах, үр дүнг судлах | жилдээ | П.Нямдаваа |
| | -Нийгмийн эмзэг бүлэгт хамаарах иргэдэд эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үзүүлэх заавар, эм олгох журам боловсруулж, мөрдөх | I улирал | П.Нямдаваа<br>Ш.Батбаяр |
| | -Халдварт өвчнийг эмчлэх, оношлох, хянах чадавхийг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэх | жилдээ | П.Нямдаваа<br>Ч.Улаан |
| **8.Эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах, эндэгдлийг багасгах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.** | -Эх барихын үзлэг, үйлчилгээний багажийн цомгийн захиалга хийж бүх баг, сумдыг хангах ажлын эхний үе шатыг зохион байгуулах | жилдээ | П.Нямдаваа |
| | -Хүүхдийн өвчний цогц хөтөлбөрийн жишгийн дагуу хүүхдийн эмчилгээнд шаардлагатай багаж бүхий зөөврийн цомгоор 150 багийг хангах | жилдээ | П.Нямдаваа |
| | -Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах | I улирал | П.Нямдаваа |
| | -Хүүхдийн яаралтай тусламж, зонхилон тохиолдох өвчнүүд болон жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийн оношлогоо, эмчилгээний стандарт боловсруулан мөрдүүлэх | жилдээ | П.Нямдаваа |
| | -Эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах хөтөлбөр боловсруулах | жилдээ | П.Нямдаваа |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| **9.Эмийн болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэгдсэн бодлого явуулж, эрүүл мэндийн технологи хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.** | -Эрүүл мэндийн технологийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч технологийн эрэлт хэрэгцээг тогтоож, Эрүүл мэндийн технологи үндэсний хөтөлбөр боловсруулах | I-III улирал | П.Нямдаваа Ч.Ганзориг |
| | -Хандивлагчдын туслалцаатайгаар оношлогоо, эмчилгээний чадавхийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлэх | жилдээ | П.Нямдаваа Ч.Улаан |
| | -Эмнэлгийн тоног төхөөремжийн хангамж, ашиглалтын нэгдсэн бодлого боловсруулах | II улирал | П.Нямдаваа |
| | -Оношлогоо, эмчилгээний бүсийн төвд шаардагдах эмнэлгийн багаж, тоног төхөөремжийн хэрэгцээг тодорхойлох, Ховд, Дорнод зэрэг аймгуудад бүсийн оношлогоо, үйлчилгээний төв байгуулах, Говь-Алтай, Булган, Баян-Өлгий, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөремжийг сайжруулах | II-III улирал | П.Нямдаваа |
| **10.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх эмчилгээнд рашааныг өргөн ашиглахын хамт түүний нөөцийг хамгаалах арга хэмжээ авна** | -Рашааны үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, мөрдөх | I-II улирал | П.Нямдваа |
| | -Зохих бэлтгэлийг хангасны дараа ашиглах боломжтой рашааныг паспортжуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах | жилдээ | П.Нямдаваа У.Барсболд |
| | -Рашааны нөөцийг хамгаалахын зэрэгцээ түүнийг зохистой ашиглах зорилгоор нөхөн сэргээх эмчилгээний аргуудтай хослон хэрэглэх аргачлал, зөвлөмж боловсруулах | жилдээ | П.Нямдаваа |
| **11.Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чанарын баталгааг хангах эрх зүйн орчныг сайжруулна** | -Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах | III-IV улирал | П.Нямдаваа |
| | -Эрүүл мэндийн байгууллагыг хувьчлах, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг дэмжих чиглэл, стратегийг шинэчлэн боловсруулах | II-III улирал | П.Нямдаваа Ч.Улаан |
| | -Эрүүл мэндийн байгууллагуудын шатлалд тохирсон бүтэц, үйл ажиллагааны стандарт боловсруулах | I-II улирал | П.Нямдаваа Ч.Ганзориг |
| **12.Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын эрүүл** | -Их спортын чиглэлээр мөрдөж байгаа санхүүжилтийн ба шагналын журмыг шинэчлэн боловсруулах | жилдээ | П.Нямдаваа Ч.Улаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| **мэндийг хамгаалах, залуу үеийн бие бялдарыг чийрэгжүүлэх чиглэлээр өргөжүүлнэ.** | -Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж мөрдөх | жилдээ | П.Нямдаваа |
| **13.Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын шинэчлэлийг эрчимжүүлж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.** | -Сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх болон их засварт шаардагдах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх | жилдээ | А.Цанжид Ч.Улаан |
| | -Ачаалал ихтэй сургуулийн барилгыг өргөтгөх, шинээр барих, хөдөөгийн сургуулиудын барилгыг засварлах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар сургалтын орчныг сайжруулах | жилдээ | А.Цанжид Ч.Улаан |
| | -Сургуулиудыг компьютержүүлэх хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх | жилдээ | А.Цанжид Ч.Улаан |
| | -Эмзэг бүлгийн өрхийн болон олон хүүхэд нь ЕБС-д зэрэг суралцдаг өрхийн 3-аас дээшхи хүүхдэд хичээлийн хэрэглэлийг үнэ төлбөргүй олгох | жилдээ | А.Цанжид Ч.Улаан |
| | -Төрөөс магадлан итгэмжлэгдсэн дотоодын их сургууль, коллежийн дипломын болон бакалаврын боловсрол олгох ангид зохих журмын дагуу элсэн суралцаж байгаа нэн ядуу өрхийн нэг, 2-оос дээш хүүхэд нь зэрэг суралцаж байгаа айлын нэг, бодг шилжүүлснээр 200 хүртэлх толгой малтай малчин өрхийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төсвөөс тус тус санхүүжүүлэх | жилдээ | А.Цанжид Ч.Улаан |
| | -Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулгыг шинэ тогтолцоонд шилжүүлэх бэлтгэл ажлыг үргэлжлүүлэх | жилдээ | А.Цанжид Ч.Улаан |
| | -Дээд боловсролын агуулгын цөм стандарт боловсруулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг өргөжүүлэх | жилдээ | А.Цанжид Ч.Улаан |
| | -Магадлан итгэмжлэлийн эрх зүйн орчныг шинэчлэн, түүний гүйцэтгэх үүргийг өндөржүүлж, хүрээг өргөжүүлэх | II-IV улирал | А.Цанжид |
| | -Сурах бичгийг шинээр зохиох, хэвлүүлэх, түгээх журмыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх | II улирал | А.Цанжид |
| | -Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах | I-II улирал | А.Цанжид |
| | -Өндөр хөгжилтэй орнуудад сургах оюутан, магистр, докторын зэрэгтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлэх | II-IV улирал | А.Цанжид |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Хүүхдийг сургуульд бэлтгэх арга зүйн асуудлаар эцэг, эхэд зориулсан гарын авлага, сургалтын материал бэлтгэж хэвлүүлэх, албан бус боловсролын хүрээнд тэдэнд зориулсан сургалтыг өргөжүүлэх | жилдээ | А.Цанжид |
| | -Багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх | жилдээ | А.Цанжид |
| | -Зайны сургалтын үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх | жилдээ | А.Цанжид |
| | -Ерөнхий боловсролын сургуулийн YIII анги төгсөгчдийн 70-аас доошгүй хувийг IX ангид элсүүлэн сургахын зэрэгцээ YIII анги төгсөгчдөөс техникийн болон мэргэжлийн сургуульд элсүүлэх хувийг нэмэгдүүлэх | II-III улирал | А.Цанжид<br>Ч.Улаан |
| | -ЕБС-ийн болон дотуур байрны зардлыг нэгжийн нормд үндэслэн санхүүжүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх | жилдээ | А.Цанжид<br>Ч.Улаан |
| | -Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Эх хэлний тухай хуулийг боловсруулан батлуулах | жилдээ | А.Цанжид |
| | -Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн хамгаалалтын орчныг бий болгох | жилдээ | А.Цанжид |
| | -Соёл, урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах | жилдээ | А.Цанжид<br>Ч.Улаан |
| | -Ардын урлагийн их наадмыг улс хувьсгалын 80 жилийн ойд зориулсан арга хэмжээ болгон зохион байгуулах | II улирал | А.Цанжид<br>Ч.Улаан |
| | -Сумдын соёлын төвүүд, номын сангийн үйл ажиллагааг сэргээх, хөдөөгийн хүн амын соёл, урлаг, мэдээллийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөтгөх судалгаа хийх | жилдээ | А.Цанжид<br>Ч.Улаан |
| | -Шинжлэх ухаан, технологийн төсөл, арга хэмжээ болон соёл урлаг, шинжлэх ухааны салбарын техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх | жилдээ | А.Цанжид<br>Ч.Улаан |
| | -Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлэх | III улирал | А.Цанжид<br>Ч.Улаан |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | ***Д. Батлан хамгаалах, гадаад бодлогын хүрээнд:*** | | |
| **1.Төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичигт нийцүүлэн батлан хамгаалах бодлогод тодотгол хийх, цэргийн шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлэхэд цэргийн байгууллалтыг боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээг дэс даратай хэрэгжүүлнэ.** | -Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгон шинэчлэх | жилдээ | Ж.Гүррагчаа |
| | - Батлан хамгаалах салбарт бүтцийн өөрчлөлт хийх асуудлыг судлан үзэж, цэргийн байгууламтыг төгөлдөржүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх | III-IV улирал | Ж.Гүррагчаа |
| | -Цэргийн шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлэн зэвсэгт хүчний бүтцийг төгөлдөржүүлж, тайван цагийн бүтэц, зохион байгууламтаараа байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадамж бүхий салбарын тоог нэмэгдүүлэх | жилдээ | Ж.Гүррагчаа |
| | -Зэвсэгт хүчин бусад цэргийн зэвсэглэл, техникийг гадаад хамтын ажиллагаанд тулгуурлан шинэчлэх ажлыг эхлүүлэх | жилдээ | Ж.Гүррагчаа |
| | -Зэвсэгт хүчний мэргэжлийн байгууллагуудыг бүтээн байгууламтын ажилд зохион байгууламттайгаар татан оролцуулах | жилдээ | Ж.Гүррагчаа |
| | -Иргэний хамгаалалтын удирдлагын шуурхай байдал, аврагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, орон нутгийн хүч хэрэгслийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа боловсронгуй болгох | Жилдээ | Ж.Гүррагчаа |
| | -Бүс нутгийн аюулгүй байдал, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх олон талт арга хэмжээнд идэвхитэй оролцох, гадаад харилцаа, хамтын ажиллагааг цэргийн боловсон хүчин бэлтгэх, зэвсэглэл техникийг шинэчлэх, сайжруулах асуудалд чиглүүлэн гадаад орны дэмжлэг авах | жилдээ | Ж.Гүррагчаа |

| 1 | 2 | 3 | 4 |
| --- | --- | --- | --- |
| **2.Улс төр, хүмүүнлэгийн гадаад харилцааг эрчимжүүлж, Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчин бүрдүүлэхийг эрхэмлэнэ.** | -ОХУ, БНХАУ-тай өндөр хэмжээний айлчлал, дээд хэмжээнд ажлын уулзалтыг зохион байгуулж, яриа хэлэлцээг бүх түвшинд явуулахын зэрэгцээ хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх, хил орчмын бүс нутгийн шууд харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хоёр талын харилцааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -АНУ, Япон Улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн, Монгол Улс дахь Японы шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хоёр орны хоорондын худалдааг өргөжүүлэх эрх зүйн орчныг бататгах | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Европын Холбоотой, тухайлбал, ХБНГУ, Франц, Итали Улстай түншийн харилцаа, хамтын ажиллагааг үргэлжлүүлэх, тус тивийн бусад орнуудтай харилцааг тогтвортой хөгжүүлэх | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Энэтхэг Улстай мэдээллийн технологи, батлан хамгаалах салбарт хамтран ажиллах, ТУХН-ийн орнуудтай дээд, өндөр хэмжээний уулзалт, яриа хэлэлцээ хийх | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Ази, Номхон далайн орнууд, тухайлбал БНСУ, БНЭУ зэрэг нөлөө бүхий орнуудтай хоёр талын харилцаагаа бэхжүүлж, АСЕАН-ы Бүсийн Чуулганы үйл ажиллагаанд идэвхтэй оролцох | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Турк, Арабын орнуудтай харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, Арабын зарим оронтой дипломат харилцаа тогтоохоор ажиллах | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -Латин Америкийн нөлөө бүхий орнуудтай хоёр талын улс төр, эдийн засгийн хүмүүнлэгийн салбарт харилцааг хөгжүүлэх | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -НҮБ, түүний харъяаллын болон олон улсын бусад байгууллага, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, 77-гийн бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох | жилдээ | Л.Эрдэнэчулуун |
| | -НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийн сан, Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Хүн амын сантай шинэ давтамжийн орны хөтөлбөрүүдийг тохиролцож байгуулах | жилдээ | Л.Эрдэнэчулуун Ч.Улаан |
| **3.Гадаад эдийн засгийн харилцааг дэмжих бодлого баримталж, олон улсын** | -Олон улсын түвшинд зээл тусламжийн болон хөрөнгө оруулалтын урсгал, чиг хандлага, туршлагыг судлан хэрэгжүүлэх | жилдээ | Л.Эрдэнэчулуун |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| түвшинд зээл тусламж болон хөрөнгө оруулалтын талаар судалгаа хийж, санал зөвлөмж боловсруулна. | -ОХУ, БНХАУ ДХБ-д элсэхтэй холбогдсон мэдээлэл боловсруулан судалгаа хийх, АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий журамд хамрагдсантай холбогдуулан уг журмын давуу талыг бодитойгоор ашиглах | жилдээ | Л.Эрдэнэчулуун<br>Ч.Улаан<br>Ч.Ганзориг |
| | -Дамжин өнгөрөх тээврийн асуудлаар ОХУ, БНХАУ-тай гурван талын хэлэлцээ байгуулах чиглэлээр ЮНКТАД-тай хамтран ажиллах | жилдээ | Л.Эрдэнэчулуун<br>Б.Жигжид |
| 4.Хилийн чанадад иргэдийнхээ эрх, ашгийг хамгаалах эрх зүйн үндсийг сайжруулж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, гадаадад суралцах, хөдөлмөр эрхлэх хууль эрхийн таатай орчин бүрдүүлнэ. | -БНСУ-д албан ёсны гэрээ, хэлэлцээрийн дагуу хөдөлмөр эрхлэх монгол иргэдийн квотын хэмжээг нэмэгдүүлэхээр ажиллах | жилдээ | Л.Эрдэнэчулуун<br>Ш.Батбаяр |
| | -Монголын иргэд гадаадад хөдөлмөр эрхлэх, суралцахад таатай нөхцөл бий болгох эрх зүйн орчин бүрдүүлэхэд чиглэсэн хоёр талын болон олон талын гэрээ, хэлэлцээр байгуулахад хүчин чармайлт гаргах | жилдээ | Л.Эрдэнэчулуун<br>Ш.Батбаяр |
| | ***Е. Эрх зүйн шинэтгэл, засаглал, хил хамгааллын хүрээнд:*** | | |
| 1.Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, хуулийн хэрэгжилт болон хорих байгууллагын үйл ажиллагаа сайжруулахад анхаарна. | -Хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор 2004 он хүртлэх эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хууль боловсруулах ажиллагаанд олон нийт болон мэргэжлийн байгууллагын саналыг түлхүү оруулах чиглэлээр хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | I-II улирал | Ц.Нямдорж |
| | -Хуулийн байгууллагын иргэн, эрүүгийн зэрэг үйл ажиллагаатай холбогдсон багц хуулийн төсөл боловсруулах | III-IV улирал | Ц.Нямдорж |
| | -Эрх зүйн сургалт, сурталчилгааг ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр явуулах | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хуульчдыг бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын хууль зүйн боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэхтэй холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэх | жилдээ | Ц.Нямдорж<br>А.Цанжид |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Хорих ял эдлүүлэх болон шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаар зохицуулж байгаа эрх зүйн орчныг боловсронгуй болгох | I-II улирал | Ц.Нямдорж |
| | -Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | I-II улирал | Ц.Нямдорж |
| | -Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд таатай эрх зүйн орчин бүрдүүлэх үүднээс холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хорих ял эдэлж байгаа хоригдлын нас баралтыг бууруулах, түүний үндсэн шалтгаан болж байгаа өвчлөл, ялангуяа сүрьеэ өвчтэй хоригдлыг тусгаарлан эмчлэх тусгай эмнэлэг, сувиллын газрыг зохион байгуулах | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хорих ял эдэлж байгаа этгээдийн талаас шинээр гэмт хэрэг үйлдэх, оргох явдлыг таслан зогсоох зорилгоор хорих ангиудын дохиолол, хамгаалалтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн төгөлдөржүүлэх | III-IY улирал | Ц.Нямдорж |
| **2.Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.** | -"Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхлэх ажлыг зохион байгуулах | жилдээ | Ө.Энхтүвшин |
| | -Яамны болон агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлж эхлэх | I-II улирал | Ө.Энхтүвшин Ц.Нямдорж |
| | -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг батлуулж, хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд тэдгээрийн бие даасан байдлыг хангах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах | I улирал | Ө.Энхтүвшин Ц.Нямдорж |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад элссэнтэй холбогдуулан Барааны тэмдгийн Олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр, Бүтээгдэхүүний загварын Олон улсын ангилал тогтоох тухай Локарны Хэлэлцээр, Барааны тэмдгийг бүртгэх, бараа үйлчилгээний Олон улсын ангиллын тухай Ниццийн Хэлэлцээр, Шинэ бүтээлийн Олон улсын ангиллын тухай Страсбургийн Хэлэлцээрт нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлэх | жилдээ | Ц.Нямдорж<br>Л.Эрдэнэчулуун |
| **5.Хилийн цэргийн бие даасан тогтолцоог төлөвшүүлж, хил хамгаалалтыг бэхжүүлнэ.** | -Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хилийн цагийн байдал, түүний цаашдын хандлагад нийцүүлэн Монгол Улсын төрөөс хилийн талаар тогтвортой баримтлах бодлого боловсруулах | II-III улирал | Ц.Нямдорж |
| | -Улсын хил, түүний хамгаалалтын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг төрийн хилийн бодлогод нийцүүлэн өөрчлөх, тодотгох | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрүүдэд үнэлгээ, шинжилгээ хийх | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Улсын хил хамгаалах шаардлагыг үндэслэн тагнуул, хэрэг бүртгэх алба, нисэх бүрэлдэхүүн, сургууль, эмнэлгийн хөдөлгөөнт бүлэгтэйгээр хил хамгаалах байгууллагын бие даасан бүтцийг бий болгох | жилдээ | Ц.Нямдорж |
| | -Монгол-Хятадын хилийг хамтран шалгах ажлыг эхлүүлэх | жилдээ | Л.Эрдэнэчулуун<br>Ц.Нямдорж |
| | -Хилийн хяналтын албадын үйл ажиллагааг боловсронгуй болгож, хилийн зөрчлийг бууруулахад чиглэсэн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх | жилдээ | Ц.Нямдорж<br>Ч.Улаан<br>холбогдох бусад сайд |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр**

**Дугаар 51**

**Улаанбаатар хот**

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Гаалийн тарифын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтад байгаа гаалийн албан татварын "5" гэсэн хувь, хэмжээг "7" гэж, мөн хавсралтын 07, 11 дэх бүлэгт заасан "9-р сарын 1" гэснийг "8-р сарын 1" гэж тус тус өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хянг: «Төрийн мэдээлэл»** эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487